



Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
2004

Энэхүү эмхэтгэлийн талаархи санал сэтгэгдлээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Эрүүл Мэндийн Яамны харьяа

Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв

Шуудангийн хаяг: Энхтайваны гудамж 136 байр

Улаанбаатар -210648

Факс: 976-11-320633

Утас: 321485, 320633

Эшуудан: hsic@magicnet.mn

Редактор: С. Дуламсүрэн АУ доктор

Эмхэтгэсэн: Д. Нямхорол, Нийгмийн Эрүүл Мэндийн магистр

Д. Баясгалан, Анаагаах Ухааны магистр

С. Ариунтуяа

Д. Оюунцэцэг

Хэвлэлийн эх бэлтгэсэн: С. Сайнтуяа

Товчилсон нэр томъёоны тайлбар

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БҮ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
АД	Аймгийн дүн
УБ	Улаанбаатар
УД	Улсын дүн
ҮСГ	Үндэсний статистикийн газар
МХЗ	Мянганы хөгжлийн зам
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвартай зам
ХДХВ	Хүний дархлалын хомсдолын вирус
ДОХ	Дархлалын олдмол хамшинж
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
СТСД	Сүрьеэтэй тэмцэх сүрьеэгийн дэд хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үргижүйн эрүүл мэнд
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент

Гарчиг

Бүлэг I. Монгол Улсын хүн ам

- 1.1 Хүн амын бодлого
- 1.2 Монгол улсын хүн ам ба хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд
- 1.3 Хүн амын насны суварга
- 1.4 Хүн амын төрөлт, нас баралт, цэвэр өсөлт

Бүлэг II. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд

Бүлэг III. Эх хүүхдийн эрүүл мэнд

- 3.1 Эхийн эрүүл мэнд
- 3.1.1 Жирэмсэний үеийн болон төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ
 - 3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ
 - 3.1.3 Төрсний дараах үеийн тусlamж үйлчилгээ
 - 3.1.4 Эхийн эндэгдэл
 - 3.1.5 Үр хөндөлт
 - 3.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ
 - 3.2 Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл мэнд

Бүлэг IV. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ

- 4.1 Эмнэлгийн анхдагч шатлалын тусlamж үйлчилгээ
- 4.2 Эмнэлгийн хоёрдогч шатлалын тусlamж үйлчилгээ
- 4.3 Эмнэлгийн гуравдагч шатлалын тусlamж үйлчилгээ

Бүлэг V. Халдварт өвчин

- 5.1 Гэдэсний халдвэр
- 5.2 Амьсгалын замын халдвэр
- 5.3 Бэлгийн замаар дамжих халдвэр

Бүлэг VI. Халдварт бус өвчлөл

- 6.1 Хүн амын өвчлөл
- 6.2 Стационарын өвчлөл
- 6.3 Хүн амын нас баралт

Бүлэг VII. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд

Бүлэг VIII. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд 2004 он

Өмнөх үг

Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн статистик мэдээллийн албанаас тогтмол цуглуулдаг албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тооцож жил бүр эмхэтгэл болгон хэвлүүлэн та бүхэнд хүргэдэг билээ.

Бид энэхүү эмхэтгэлээ 2001 оноос эхлэн монгол-англи хэлнээ эрхлэн гаргадаг болсноор манай эрүүл мэндийн салбарт хамтран ажилладаг олон улсын байгууллагууд болон зөвлөхөөр ажиллаж буй хүмүүс ашиглах боломжийг бүрдүүлж өгсөн юм.

2004 онд эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг анх удаа эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар тооцон гаргаснаас гадна мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд, эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний зарим хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн статистик тоо баримтыг нэгтгэн оруулснаар шинэлэг болсон гэж үзэж байна.

Эхийн эндэгдэлийг бууруулах 2001-2004 оны стратеги төлөвлөгөө амжилттай хэрэгжсэний үр дүнд хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн нэг болох эхийн эндэгдэл сүүлийн 20 жилд анх удаа хамгийн бага түвшинд хүрч, хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илтгэх чухал үзүүлэлтийн нэг болох нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 10 жилд тууштай буурч байгаа зэрэг үзүүлэлтүүдийг та бүхэн энэхүү эмхэтгэлээс үзэх болно.

Бүх түвшний эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргачид болон бусад мэдээлэл хэрэглэгчдэд нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхэтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж, улам боловсронгуй болгох санал зөвлөмж бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байна.

ЭМХҮТӨВИЙН ЗАХИРАЛ

С.ДУЛАМСҮРЭН

БҮЛЭГ I

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

1.1 Хүн амын бодлого

Монгол улс 1994 оны Кайрын “Хүн ам ба хөгжил” олон улсын бага хурлын шийдвэрийг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлэх үүднээс Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг 1996 онд баталсан. Энэхүү бодлогын баримт бичгийг хүн амын өсөлтийн сааралтаас үүдэн гарч буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олон улсын хэмжээнд хэлэлцэн зөвшилцсэн стратегийн баримт бичгүүдтэй уялдуулах шаардлагын улмаас “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” нэртэйгээр шинэчлэн боловсруулж, 2004 оны 5-р сард Улсын Их Хурлаар баталсан. Энэхүү бодлогыг Монгол улсын хөгжлийн болон Мянганы хөгжлийн зорилтыг дүгнэх үе шаттай уялдуулан 2015 он хүртэл дараах 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат: 2004-2007 он

Хоёрдугаар үе шат: 2008-2011 он


Гуравдугаар үе шат : 2012-2015 он

1.2 Монгол улсын хүн ам ба хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

2004 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хүн ам 2 сая 533.1 мянгад хүрч нийт хүн амын 50.4 төв суурин газар, үлдсэн 49.4 хувь нь хөдөө амьдарч байна. Нийт хүн амын 48.8 хувийг эрэгтэйчүүд, 51.2 хувийг эмэгтэйчүүд, 30.3 хувийг 15 хүртэлх наслы хүүхэд, 65.7 хувийг 15-64 наслы хүн ам, 4.0 хувийг 65 түүнээс наслы хүн ам эзэлж байна. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хүйсийн харьцаа 100: 95.5 байгаа бөгөөд хот суурин газарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс өндөр байдаг ч газар зүйн байршилаас хамааран онцлог, ялгаатай харьцаа байдаг байна.


Зураг 1.1

2004 оны дундаж хүн амын тоо, аймгаар



Зураг 1.2


Хот, суурин газар амьдардаг хүн амын эзлэх хувь, аймгаар



1.3 Хүн амын насны суварга

Монгол Улсын хүн амын дийлэнх хувийг залуучууд эзэлж байгаа болон сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин буурсантай холбоотойгоор хүн амын нас, хүйсийн бүтцэд гарсан өөрчлөлтийг 1992, 2004 оны хүн амын суваргаас харж болно.

Зураг 1.3 Хүн амын насны суварга 1992 он ба 2004 он



1.4 Хүн амын төрөлт, нас барагт, цэвэр өсөлт

Монгол Улсын Хүн амын тоо 1918-1969 оны хооронд 2 дахин өсч байсан бол 1969-1989 оны хоорондхи 20-иод жилийн дотор мөн л 2 дахин нэмэгдсэн ч 1980-иад оны дунд үеэс хүн амын төрөлт аажим буурч эхэлсэн бөгөөд 1990 оноос хойш төрөлтийн бууралт улам түргэссэн гэж хүн ам зүйчэд үздэг. Манай улсын хүн амын өсөлтийн хурдац буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл бол төрөлтийн бууралт юм. 1990 онд 1000 хүн амд 35,3 төрөлт ногдож байсан бол 2004 онд 17.7 болж буурсан байна.

Төрөлтийн түвшинг тодорхойлдог төрөлтийн өрөнхий, тусгай, насын бүлэг дэх болон төрөлтийн нийлбэр коэффициентуудыг НҮЭМ-ийн 1998, 2003 оны үндэсний судалгаагаар тооцсон үзүүлтүүдээр харьцуулан хүснэгт 1.1 үзүүлэв. Эдгээр үзүүлэлтүүдийг 1998 оны судалгаатай харьцуулахад төрөлтийн коэффициент 20-24 насанд хамгийн өндөр, 15-19 насны эмэгтэйчүүдэд хотод бага зэрэг буурч, хөдөөд өсөх хандлагатай байгаа хэдий ч 2003 оны судалгааны дүнгээр насны бүлэг дэх төрөлтийн коэффициент нь 1998 оныхоос мэдэгдэхүйц буурч байгаа нь бүх насны бүлэгт ажиглагдаж байна.¹

Хүснэгт 1.1 Төрөлтийн коэффициентүүд насны бүлэг, байршилаар

НҮЭМС 1998 ба 2003 оны судалгааны үр дүнгээс

Үзүүлэлт	Байршил		НҮЭМС-2003	НҮЭМС-1998
	Хот	Хөдөө		
Насны бүлэг				
15-19	33	81	53	54
20-24	149	197	173	216
25-29	124	155	140	169
30-34	73	92	82	105
35-39	41	45	43	50
40-44	7	8	7	18
45-49	1	0	1	0
Төрөлтийн коэффициентүүд				
THK	2.14	2.89	2.5	3.06
TTK	72	104	87	113
TEK	18.9	26.7	22.6	28.5

Эх сурвалж: НҮЭМС 2003, УСГ
Тайлбар: THK - Төрөлтийн нийлбэр коэффициент
TTK - Төрөлтийн тусгай коэффициент

TEK - Төрөлтийн өрөнхий коэффициент

БҮЛЭГ II

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

МХЗ-ыг 2000 оны 9 сард Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтанд оролцсон дэлхийн 191 үндэстнийг төлөөлсөн 147 орны төр засгийн тэргүүнүүд баталж, тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэх асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгосон билээ. Эдгээр зорилтууд нь сүүлийн 10 жилийн турш НҮБ-аас зохион байгуулсан дэлхийн чуулга уулзалтуудын тогтоол, шийдвэрүүдээс урган гарсан ба дэвшлийг хэмжих хэмжүүр болж байна.²


МХЗ-ын хүрээнд эрүүл мэндтэй холбоотой хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийн сайжруулах, ХДХВ/ДОХ, хумхаа болон бусад өвчинтэй тэмцэх гэсэн 3 зорилго, 6 зорилт дэвшүүлсэн байдаг.

Зорилт 6
1990-2015 онд 5 хүртэлх насын хүүхдийн

Үзүүлэлт	1990	2000	2004	2015
5 хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөнд)	87.5	42.4	29.1	29.2
Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөнд)	63.4	31.23	22.8	-

Зураг 1.1

эндэгдлийг гуравны хоёроор



Өнөөгийн байдал

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол улсад нялхас болон 5 хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой буурсан нь өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент, хөхөөр хоололтыг дэмжих зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй зүй ёсоор холбоотой² ба 1990-2000 оны хооронд энэ үзүүлэлт 2 дахин буурч, 2004 оны байдлаар 29.2 түвшинд хүрсэн байна.

Хэрэгжих таатай орчин


Монгол улс 5 хүртэлх насын хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилтоо эрүүл мэнд, нийгмийн хэдэн хэдэн хөтөлбөр, бодлогын барим бичигт тусгасан. Тус улс 1992 онд Хүүхдийн эрхийн тухай конвенцэд нэгдэн орсон ба 1990-2000 онд Хүүхдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, 2002-2010 онд Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг тус тус баталсан байна. Түүнчлэн Үндсэн хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу 16 хүртэлх насын хүүхдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний зардлыг төр хариуцна гэж заасан байдаг. Монгол улс эх хүүхдийн тусlamж үйлчилгээний нэлээд сайн тогтолцоотой бөгөөд эхчүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр, боловсрол, эрүүл мэнд болон хоол тэжээлийн талаар хүүхдийг хүйсээр ялгаварлан гадуурхах уламжлал үгүй.³

Зорилт 7

Нөхөн үргижүйн эрүүл мэндийн шаардлагатай тусlamж үйлчилгээг зохих наасны хүн бүрт хүргэж, 1990-2015 онд эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах

Үзүүлэлт	1990	2000	2004	2015
Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөнд)	199 (1992)	158.5	98.8	50
Эмч, эмнэлгийн мэргэжилтний удирдсан төрөлтийн хувь	-	-	99.5	99.8

2.2 Эхийн эндэгдлийн түвшин 100000 амьд төрөлтөнд



Өнөөгийн байдал

Монгол улс 1990-2000 оны хооронд эхийн эндэгдлийн түвшингээрээ бүсийн орнууд болон хөгжилтэй оронтой харьцуулахад харьцангуй эндэгдэл өндөртэй оронд тооцогдож байсан ба эхийн эндэглийн түвшин буурахгүй өндөр хэвээр байсан. Харин 2000 онд 100 000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэглийн түвшин 124 болж буурч, улмаар 2003 онд 109.5 болсон нь сүүлийн 10 гаруй жилд хамгийн бага түвшинд хүрч, 2004 онд анх удаа 2 оронтой тоонд шилжсэн буураалт ажиглагдсан нь эхийн эндэгдлийн түвшин цаашид тогтвортой буурах хандлага байгааг харуулж байна.

Төрөх наасны эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн аргуудын хэрэглээ эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээллээр 2000 онд 49.1 байсан бол 2004 онд 51.3 болж нэмэгдсэн байна.

Хэрэгжих таатай орчин

Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах зорилтыг “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2004 он), засгийн газраас баталсан “Эхийн эндэглийг бууруулах стратеги” (2000 он), “HYЭM-ийн үндэсний хөтөлбөр” болон бусад хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж байна.

УИХ-аас баталсан “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”-д (2001 он) эмзэг бүлгийнхэн, алслагдмал бүс нутагт амьдардаг иргэдэд үзүүлэх нөхөн үргижүйн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг сайжруулах асуудлыг онцлон тусгасан байна.³

Зорилт 8

2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг зогсоож, БЗДХ-ыг бууруулж эхлэх

Үзүүлэлт	1990	2000	2004	2015
15-24 наасны жирэмсэн эхчүүдийн дундах ХДХВ-ийн гаралт	0	0	0	0
Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хэрэглээний хувь	-	49.1	51.3	-
Хүний Дархлал Хомсдолын Вирус/Дархлалын Олдмол Хомсдолын өвчний улмаас өнчирсөн хүүхдийн тоо	-	-	-	-

Өнөөгийн байдал

Монгол улс ХДХВ/ДОХ-ын гаралт багатайд тооцогддог. 1992 онд ХДХВ-ийн халдварт авсан анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 1997, 2001, 2003, 2004 онд халдварт авсан 4 тохиолдол бүртгэгдээд байгаа ба 2 нь ДОХ өвчний улмаас нас барсан байна. ХДХВ/ДОХ-ын тархалтын түвшин бага байгаа нь сэтгэл тайвширах шалтгаан биш бөгөөд Монгол улс халдвартархах эрсдэл өндөр орны тоонд орох хэд хэдэн хүчин зүйл байдаг. Үүнд хүн ам харьцангуй залуу буюу нийт хүн амын 50 гаруй хувийг 23 хүртэлх насны залуучууд эзэлдэг, сүүлийн жилүүдэд бэлгийн замаар дамжих халдвартогтвортой нэмэгдэж байгаа, хөдөөнөөс хот руу шилжин ирэгсэд болон улс хоорондын зорчигчдын тоо хурдацтай нэмэгдэж байгаа, хөрш зэргэлдээ ОХУ болон Хятад улсуудад ХДХВ-ийн халдварт сүүлийн жилүүдэд хурдацтай тархаж байгаа зэрэг хүчин зүйлүүдийг хамааруулж үздэг.

Хэрэгжих хууль эрх зүйн орчин

ХДХВ/ДОХ –той тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал нь Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, ДОХ-той тэмцэх үндэсний хөтөлбөр (), “ХДХВ/ДОХ-оос сэргийлэх “тухай хууль (2004 он), НҮЭМ-ийн үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичигт тусгагдсан.³

Зорилт 9

2015 онд гэхэд сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх

Үзүүлэлт	1990	2000	2004	2015
Сүрьеэ өвчний тархалт (100 000 хүн амд)	79	61	90	40
Сүрьеэ өвчний нас баралтын түвшин (100 000 хүн амд)	5	3.2	2.94	-
ДОТС-ын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь	-	100/80	100/83.8	-

Зураг 2.3 Сүрьеэгийн бүрэн эдгэрэлтийн хувь, нас баралтын түвшин 100000 хүн амд 1993-2004



Өнөөгийн байдал

Монгол улс ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн сүрьеэгийн өвчлөл өндөр зэрэглэлтэй 5 оронд багтдаг. Сүрьеэгийн өвчлөлийн тархалт 1990 онд 100 000 хүн амд 79 байсан бол 2000 онд 2004 онд болж нэмэгдсэн байна. Монгол улс 1995 оноос Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд оношилгоо эмчилгээний олон улсын стандарт (ДОТС)-ыг нэвтрүүлж, амжилтай хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд ДОТС-ын хамралт 1995 онд 6,5 хувь байсан бол 2004 онд 100 хувь болж өссөн байна.

Хэрэгжих хууль эрх зүйн орчин

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого болон Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрт эмчилгээ, оношилгооны шинэ стратегийг тусгасан. Холбогдох хуулийн дагуу сүрьеэгээс сэргийлэх, оношлох, эмчлэхтэй холбоотой эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой даатгал, зардлыг төрөөс хариуцдаг.³

БҮЛЭГ III

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

3.1 Эхийн эрүүл мэнд

2004 онд :

- Эхийн эндэгдлийг бууруулах 2001-2004 оны стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж, эхийн эндэгдлийг бууруулах 2005-2010 оны стратегийг баталлаа
- 2004-2008 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, мянганы хөгжлийн зорилтод нийцүүлэн эх хүүхдийн/ нярайн/ эндэгдлийг бууруулна гэж заасан байна.
- Сүүлийн 10 гаруй жилийн турш монгол улсад эхийн эндэглийн түвшин тогтвортой буурахгүй 100 000 амьд төрөлтөнд дунджаар 177 эндэгдэл ногдож байсан бол 2003 онд 109.5 болсон нь сүүлийн 10 жилд хамгийн бага түвшинд хүрч, 2004 онд анх удаа эхийн эндэгдлийн түвшин 2 оронтой тоонд шилжин буурсан үзүүлэлт гарсан.

Зураг 3.1 Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөнд /1994-2004/



3.1.1 Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ

Жирэмсэн эмэгтэйд үзүүлэх төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд дараах үйл ажиллагаануудыг хамруулан ойлгодог. Үүнд:

- Жирэмсний эрт илрүүлж, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтанд авах
- Жирэмсэн эхчүүдийг цусны өрөнхий шинжилгээ, БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулах
- Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, тэдгээрийг эрт илрүүлэх, цаг алдалгүй эмчлэх
- Жирэмсэн эхчүүдийг амин дэм болон бичил элемэнтээр хангах
- Эхчүүдийн амрах байрны үйлчилгээг сайжруулах


Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтанд орох нь хавсарсан өвчлөлийг оношлох, эмчлэх улмаар жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

2004 оны байдлаар нийт жирэмсэн эхчүүдийн 77.6 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан байна. Хот, хөдөөгөөр авч үзэхэд хотод төрсөн эхчүүдийн 67.4 хувь нь, хөдөө төрсөн эхчүүдийн 83.1 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтанд хамрагдсан байна. Улаанбаатар хотод жирэмсний хяналтад хамрагдсан болон жирэмсний эхний 3

сартайдаа хяналтанд авсан хувь аймгийн дундажаас бага байгаа нь хүн амын шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой юм.

Шинээр хяналтанд авсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 81,4 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдснаас 14.4 хувь нь цус багадалтай гэсэн үзүүлэлттэй байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 6.2 пунктээр буурсан байна.

Зураг 3.2 Цус багадалтай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, 2004 он




Энэ онд жирэмсэн эхчүүдийн 61.2 хувь нь тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ хийлгэснээс 1.13 хувьд нь тэмбүүгийн өвчлөл илэрсэн ба энэ үзүүлэлт нь Дорнод, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Улаанбаатар хотод өндөр байна. Нийт жирэмсэн эхчүүдийн 4.4 хувь нь рентгений шинжилгээнд хамрагдснаас идэвхитэй сүрьеэгийн 119 тохиолдол илэрснээс 89.0 хувь нь Улаанбаатар хотод байна.

2004 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 333 ажиллаж байгаагаас 311 нь сумын төвд, 21 нь аймгийн төвд, 1 нь бусад газарт ажиллаж байна. Эдгээр байрны 115 нь зориулалтын байранд байгаа ба 218 нь эмнэлэг дотор байрлаж байна. Эхчүүдийн амрах байрны дундаж ор хоног 9.06 байна.

Жирэмсэн эхчүүд эмчид эрт үзүүлж төртлөө байнга хяналтанд байх нь жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэхэд онцгой ач холбогдолтой

Зураг 3.3 Жирэмсэн байхдаа 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2004 он



байдаг учраас хэвийн явцтай жирэмснийг жирэмсний хугацаанд 6 удаа үзэхээр заасан бөгөөд энэ үзүүлэлтийг 2003 оноос эрүүл мэндийн салбарын хэмжээний үзүүлэлтэнд тооцож байгаа билээ. 2004 оны байдлаар жирэмсэн байх үедээ 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 79.7, хяналтанд ороогүй эмэгтэйчүүдийн хувь 1.2 байна.

Архангай, Баянхонгор, Хэнтий, Баян-Өлгий, Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай зэрэг аймагт төрсөн эхчүүдийн 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан хувь улсын дундажаас бага байна.

3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ

2004 оны байдлаар улсын хэмжээнд нийт 44591 эх төрсөн нь 2003 онтой харьцуулахад төрөлт Баянхонгор, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Улаанбаатар хотод нэмэгдэж бусад аймгуудад буурчээ.

Төрж байгаа эхчүүдийн 36.9 хувь нь УБ хотод, 39.7 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 25.1 хувь нь сумын болон сум дундын эмнэлэгт, 0.8 хувь нь гэртээ төрсөн байна. 2000 онтой харьцуулахад гэрийн төрөлт 1.3 дахин буурсан нь эмнэлгийн хяналтанд төрөх хувь нэмэгдснийг харуулж байна. Эмнэлгийн тусlamжгүй төрөлт хотод 34, хөдөөд 110 тохиодол бүртгэгдсэн нь ба 2000 онтой харьцуулахад нийт төрөлтөнд эмнэлгийн тусlamжгүй төрөлтийн эзлэх хувь 1.2 дахин буурчээ.

Хүс нэгт 3.1 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2004 он

Аймаг хот	Нийт төрөлт	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Үүнээс сумын эхчүүд /хувь/	Сумын эмнэлэгт	Гэртээ	Бага эмчийн салбарт	Хувийн эмнэлэгт
Архангай	1546	716	54.3	824	6	0	0
Баян-Өлгий	2768	1271	48.8	1495	2	0	0
Баянхонгор	1592	953	54.8	626	5	0	8
Булган	691	401	79.8	282	5	3	0
Говь-Алтай	1138	497	43.7	624	10	7	0
Говьсүмбэр	234	232	7.3	2	2	0	0
Дархан-Уул	1383	1276	5.7	87	21	0	0
Дорноговь	907	616	48.4	285	6	0	0
Дорнот	1403	1225	37.1	172	2	0	0
Дундговь	816	511	57.5	302	3	0	0
Завхан	1316	715	36.6	601	0	0	0
Орхон	1318	1280	2	25	13	0	0
Өвөрхангай	2170	1325	59.8	819	6	3	17
Өмнөговь	933	636	63.1	293	4	0	0
Сүхбаатар	935	585	67.4	346	4	0	0
Сэлэнгэ	1263	835	38.4	418	10	0	0
Төв	736	351	30.5	385	0	0	0
Увс	1828	809	40.8	980	5	34	0
Ховд	1926	1009	44	899	18	0	0
Хөвсгөл	2201	1085	45.2	1110	1	5	0
Хэнтий	1190	584	50.2	593	11	3	0
Аймгийн дүн	28294	16912	41.8	11168	134	55	25
Улаанбаатар	16297	799	10	14	210	0	197
Улсын дүн	44591	17711	40.3	11182	344	55	222

Нийт төрсөн эхчүүдийн 7.4 хувь нь 20-иос доош насны, 83.1 хувь нь 20-34 настай, 9.5 хувь нь 35-аас дээш настай байна. НҮЭМ-ийн 1998 оны судалгаагаар 15-19 насны охидын 9 хувь нь хүүхэд төрүүлж байсан бол 2003 онд 7 хувь болж буурчээ. 1998 онд хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын хувь хотод 5.7, хөдөөд 12.9 байснаа 2003 онд хотод 4.6, хөдөөд 11.6 болсон байна.

Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр 2004 оны байдлаар 20-иос доош насны охидын жирэмслэлтийн эзлэх хувь нийт жирэмсэнд 7.0 хувь, төрөлтийн эзлэх хувь нийт төрөлтөнд 7.4 хувь байгаа бөгөөд Улаанбаатар хотод хөдөөтэй харьцуулахад бага зэрэг өндөр байна.

Нийт төрсөн эмэгтэйчүүдийн 25.6 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчинеэр өвдсөн байна. Үүнээс 45.5 хувь нь шээс бэлгэсийн тогтолцооны өвчин, 12.3 хувь нь цусны эргэлтийн тогтолцооны өвчтэй байна.

Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 21808 тохиолдол бүртгэгдснээс 38.1 хувийг жирэмсэн үеийн, 46.4 хувийг төрөх үеийн хүндрэл, 2.9 хувийг төрсний дараах үеийн хүндрэл, 12.5 хувийг жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчин тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд амьд төрсөн 44521 хүүхдийн 4.1 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Энэ үзүүлэлт нь Улаанбаатар хот, төвийн болон хангай.govийн бус нутгуудад өндөр байна. Амьгүй төрөлт баруун бүсэд улсын болон аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна. Амьгүй төрөлтөнд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь ихэнхи бус нутагт өндөр байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 103.9 байна. Амьд төрсөн хүүхдээс 786 хоёр ихэр, 14 гурав ихэр байна.

Хүснэгт 3.2 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2004 он

Бүсээр	Төрсөн хүүхэд			Нийт төрөлтөд		Амьгүй төрөлтэд эрэгтэй хүүхдийн эзлэх
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	2500 граммаас доош жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн эзлэх хувь	
Баруун бус	4342	4497	96.6	3.3	2.3	54.2
Төвийн бус	3910	8681	106.2	4	0.9	61.1
Хангай,.govийн бус	4272	3935	108.6	3.7	0.8	55.9
Зүүн бус	1818	1716	105.9	2.8	0.8	40
Аймгийн дүн	14342	13829	103.7	3.5	1.3	54.7
Улаанбаатар	8344	8006	104.2	5.1	0.7	46.8
Улсын дүн	22686	21835	103.9	4.1	1.1	52.9

3.1.3 Төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ

Төрсний дараах үеийн зөвөлгөө өгөх үйлчилгээ нь заруу эхчүүдэд хүүхдээ асрах, хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр хамардаг.

НҮЭМ- 2003 судалгааны үр дүнд сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 62 хувь нь хамгийн сүүлчийн хүүхдээ төрүүлснээс хойш 42 хоногийн дотор эмчээс зөвөлгөө авсан. Эдгээр эмэгтэйчүүдийн 60 хувь нь хөхөөр хооллолт, 59 хувь нь нярайн асаргаа, 37 хувь нь гэр бүл төлөвлөлт, 32 хувь нь БЗДХ гэсэн чиглэлээр зөвөлгөө авчээ.


2004 онд 1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 98.0, 5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 89,5 байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 5 жилд нэмэгдсэн нь эх, хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний хүртээмж сайжирч байгааг харуулж байна.

3.1.4 Эхийн эндэгдэл

Монгол улс эхийн эндэгдэл өндөртэй орны тоонд багтсаар байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд эхийн эндэгдэлийг туштай бууруулах ажлыг эрчимтэй явуулсны үр дүнд 100000 амьд төрөлтөнд 158.5 байсан эхийн эндэгдэл 2004 онд 98.8 болж 59.7 пунктээр буурлаа.

2004 онд 44 эх эндсэнээс Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Увс, Өмнөговь зэрэг аймагт эхийн эндэгдэл гараагүй байна. Эндсэн эхчүүдийн 27.3 хувийг 35-аас дээш насны, 72.7 хувийг 20-34 насны эмэгтэйчүүд эзэлж байна. Байршилаар авч үзэхэд нийт эндсэн эхчүүдийн 2/3-аас илүү хувь нь хөдөөд байна.

Зураг 3.4 Эхийн эндэгдэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар



Эхийн эндэгдлийн шалтгаанд жирэмсэн үеийн хүндрэл 22.7 хувь, төрөх үеийн хүндрэл 25.0 хувь, төрсний дараах үеийн хүндрэл 6.8 хувь, жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчин 45.5 хувь эзэлж байна. Эндсэн эхчүүдийн 38.6 хувь нь малчин, 45.5 хувь нь гэрийн ажилтай эхчүүд байгаа нь анхаарал татаж байна.

3.1.5 Үр хөндөлт

Монгол улсад хүн амын НҮЭМ-ийн нэг тулгамдаж байгаа асуудал бол үр хөндөлтийн түвшин буурахгүй байхын зэрэгцээ үр хөндөлтийн тоо бодитойгоор мэдээлэгдэхгүй байгаа явдал юм. НҮЭМ-2003 судалгааны үр дүнгээр судалгааны өмнөх 5 жилийн хугацаанд үр хөндөлт 1000 амьд төрөлтөнд 214, нөхөн үргижүйн насны 1 эмэгтэйд 0.7 байлаа. Эрүүл мэндийн 2004 оны статистикаар 1000 амьд төрөлтөнд 200, нөхөн үргижүйн насны 1000 эмэгтэйд 12 үр хөндөлт тус тус ногдох байна. Эрт үеийн үр хөндөлтийн хувь 93.8 байна.

Насны булгээр авч үзэхэд нийт үр хөндөлтийн 7.6 хувийг 20-иос доош насны, 65.6 хувийг 30-34 насны, 26.7 хувийг 35 дээш насны эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

3.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ /ЖСА/

Монгол улсын хүн амын дунд жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн талаарх мэдлэг, хэрэглээ өсч байгаа нь эмэгтэйчүүд болон хосуудад төрүүлэх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацааг зохицуулах боломжуудыг нэмэгдүүлж, хууль бус үр хөндөлтийг бууруулах нэг арга зам болж байна. НҮЭМ-ийн 1998 оны судалгаагаар орчин үеийн ЖСА-ын хэрэглээ 33 хувиас 2003 онд 45 хувь болтлоо ессөн байна. Эрүүл мэндийн статистик мэдээгээр орчин үеийн ЖСА-ын хэрэглээний түвшин 2001 онд 41.86 хувьтай байсан бол 2004 онд 51.5 болж ессөн байгаа зэрэг нь Монголд НҮЭМ-ийн хүртээмж, чанар сайжирч байгаагийн бодит илрэл мөн.


НҮЭМ-ийн 2003 оны судалгаагаар өсвөр насны эмэгтэйчүүдийн дөнгөж 4 хувь нь жирэмслэхээс сэргийлэх ямар нэг орчин үеийн арга хэрэглэж байгаа нь өсвөр насны охидын дунд хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн түвшин буурахгүй байгаагийн шалтгаан болж байна.

3.2 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөл эндэгдэл

Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод 2015 он гэхэд нялхсын эндэгдлийг 2000 оны түвшнээс 1/3-ээр бууруулна хэмээн тодорхойлсон байдаг. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илтгэх үзүүлэлтүүд болох нялхсын болон 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл нь сүүлийн 10-15 жилд тогтвортой буурах хандлагатай байна.

2003 оны НҮЭМ-ийн судалгааны үр дүн болон 2001-2003 оны эрүүл мэндийн статистик мэдээлэлд үндэслэн тооцсон нялхсын эндэгдлийн түвшин ойролцоо гарсан байна.

Зураг 3.5 Нялхсын эндэгдэл, судалгаатай харьцуулсан байдал /1998 он, 2003 он/



2004 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 29.1 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.2 пунктээр, нялхсын эндэгдлийн түвшин 22.8 байгаа нь 0.7 пунктээр тус тус буурчээ.

Амьгүй төрөлтийн түвшинг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 1.3 пунктээр буурсан хэдий ч перинатал эндэгдэл 1.2, нярайн нас баралт 2.2 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.3 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт шалтгаанаар, байршилаар

	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	15.21	33.92	19.03	34.22
Хоол шингээх эрхтний өвчин	5.15	6.37	7.4	8.13
Төрөх тойрны /перинатал/ үед үүсэх оёг	57.99	39.33	47.57	29.98
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	11.6	7.17	9.73	6.55
Бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар	3.09	6.21	8.25	10.56
Бусад	6.96	7.01	8.03	10.56
Бүгд	100	100	100	100

Тэргүүлэх шалтгаан	Тэргүүлэх шалтгаан
Хоёр дахь шалтгаан	Хоёр дахь шалтгаан
Гуравдугаар шалтгаан	Гуравдугаар шалтгаан

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд төрөх тойрны (перинаталь) үед үүсэх оёг 46.5, амьсгалын эрхтний өвчин 27.1, төрөлхийн хэв гажиг, хэв гажил өнгөт цогцын гажуудал 8.9 хувиар эхний 3 байр эзэлж байна. Өмнөх онуудад хоол шингээх эрхтний өвчин нялхсын эндэгдлийн шалтгаанд 3-р байранд байснаа энэ онд 4-р байранд оржээ. Энэ нь ХӨЦМ төсөл болон хүүхдийн амьсгалын замын халдварт, суулгалт өвчинтэй тэмцэх хөтөлбөрүүд амжилттай хэрэгжснээр хүүхдийн өвчлөл эндэгдэл тууштай буурч байгаагийн үр нөлөө юм. Байршилаар авч үзэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанаар хотод төрөх тойрны /перинатал/ үед үүсэх зарим оёгийн өвчлөл тэргүүлж байхад, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байна.

5 хүртэлх насны хүүхдийн нас баралтыг бууруулах үндэсний зорилтод 2001 оны 40.8-ыг 2005 онд 37 болгохоор заажээ. Сүүлийн жилүүдэд 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт тууштай буурч байгаа ба энэ онд 1000 амьд төрөлтөнд 29.1 байна. 5 хүртэлх хүүхдийн эндэгдлийн шалтгаанд төрөх тойрны үед үүсэх оёг 36.4 хувь, амьсгалын эрхтний өвчин 29.2, бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгаантай үр дагавар 9.7 хувь тус тус эзэлж байна.

Түүнчлэн нялхас болон хүүхдийн өвчлөлийн шалтгааныг байршилаар авч үзэхэд харилцан адилгүй байна.

Хүснэгт 3.4 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл шалтгаанаар, байршилаар 2004 он

	0-1 насны		1-4 насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	49.24	69.98	46.41	67.32
Хоол шингээх эрхтний өвчин	13.17	11.37	11.23	12.45
Төрөх тойрны /перинатал/ үед үүсэх оёг	8.41	1.33	-----	---
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	3.4	0.9	12.87	2.4
Халдварт ба шимэгчт зарим өвчин	2.31	0.3	6.63	3.4
Чих ба хөхөнцрийн өвчин	2.9	5.93	1.97	2.6

	Тэргүүлэх шалтгаан		Тэргүүлэх шалтгаан
	Хоёр дахь шалтгаан		Хоёр дахь шалтгаан
	Гуравдугаар шалтгаан		Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн, шээс – бэлгэсийн тогтолцооны эмгэгүүд, осол гэмтэл, хордлогын шалтгаантай өвчин илүүтэй тохиолдож байна.

Хүснэгт 3.5 Хүүхэд өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр, 2004 он

	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	271.5	103.2	94.1	65.9
Хоол шингээх эрхтний өвчин	54.3	51.3	60.5	63
Халдварт ба шимэгчт зарим өвчин	20.3	13.2	8.2	12.42
Чих ба хөхөнцрийн өвчин	13.7	10.9	11.9	10.2
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	8.9	12.4	23.7	42.9
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	26.7	21	25.2	32.1

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

БҮЛЭГ IV

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эмнэлгийн тусlamж үйлчилгээ 3 шатлалт тогтолцоотой бөгөөд эмнэлгийн тусlamж үйлчилгээний талаар баримтлах үндсэн зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй, чанартай үзүүлэх явдал юм.

2004 оны байдлаар клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг-17, бүсийн оношилгоо эмчилгээ төв-3, аймгийн нэгдсэн эмнэлэг болон хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 22, дүүргийн нэгдсэн эмнэлэг-12, сумын эмнэлэг –230, сум дундын эмнэлэг-31, өрхийн эмнэлэг- 230, хувийн эмнэлэг-577, эм ханган нийлүүлэх байгууллага-117, эмийн үйлдвэр-37, эмийн эргэлтийн сан-223, хувийн эмийн сан- 547 болон бусад эрүүл мэндийн байгууллагуудыг оруулаад нийт 2237 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 4.1 Эмнэлгийн байгууллагууд тусlamж үйлчилгээний шатлалаар

Аймгийн нэр	Сум, дүүртийн тоо	Бага эмчийн ортой салбар/ Их эмчийн ортой салбар	Сумын эмнэлэг/ Сум дундын эмнэлэг	Аймгийн дүүргийн нэгдсэн эмнэлэг/ Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн ортой эмнэлэг	Хувийн үүдэн эмнэлэг
Архангай	19	0	17/2	1	4	3	2
Баян-Өлгий	14	0	12/2	1	5	1	2
Баянхонгор	20	0	18/2	1	5	6	12
Булган	16	5/1	14/2	1	3	4	1
Говь-Алтай	18	1	15/2	1	4	2	2
Говь-Сүмбэр	3	0	2/0	1	1	0	1
Дархан-Уул	4	0	3/0	1	10	9	16
Дорноговь	14	0	14/1	1	3	3	12
Дорнод	14	0	19/3	0	6	0	5
Дундговь	15	0	14/1	1/1	3	2	4
Завхан	24	0	19/3	1	7	2	2
Орхон	2	0/1	1/0	1	15	6	24
Өвөрхангай	19	1	16/1	0/1	7	2	8
Өмнөговь	15	0	13/1	1	3	1	3
Сүхбаатар	13	0	11/1	1	3	3	2
Сэлэнгэ	17	0	19/1	1/1	12	6	9
Төв	27	0/1	26/0	1	4	3	3
Увс	19	1	17/1	1	5	3	2
Ховд	7	0	14/2	0	6	4	10
Хөвсгөл	24	1	19/4	1	5	8	2
Хэнтий	17	2	17/2	1/1	3	2	6
Улаанбаатар	9	0	5/0	12/0	116	73	306
Бүгд	340	11/3	296/31	18/16	230	143	434

Эх сурвалж : Сумын тоог ҮСГ-ын мэдээллээс авч нэгтгэв.

2004 онд 10000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо 72.9 болж 2003 оноос багассан боловч нийт орны тоонд хувийн эмнэлгийн орны эзлэх хувь 9.5 байсан бол 10.0 хувь болж, хэвтэн эмчлүүлэгчдийн 9.1 хувь хувийн эмнэлэгт ногдож байсан нь 10.4 хувь болж тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 4.2 Эмнэлгийн тусlamж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд шатлааар

Үзүүлэлтүүд	Тоо	Орны тоо	Хэвтэн эмчлүүлэгчид	Амбулаторын үзлэгийн тоо
Анхдагч шатлалын эмнэлгүүд	571	4579	152022	7712980
Сумын эмнэлэг	296	3866	129126	2227062
Сум дундын эмнэлэг	31	713	22896	355071
Өрхийн эмнэлэг	230	-		5130847
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	34	4644	136652	3388714
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	4	282	8588	123563
Аймгийн нэгдсэн эмнэлэг	18	3089	82202	1614236
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12	1273	45862	1650915
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	20	5815	166044	1395239
Бүсийн оношилгоо, эмчилгээ төв	3	1635	55650	333372
Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүд	17	4180	110394	1061867
Хувийн ортоj эмнэлгүүд	143	1839	58013	-
Хувийн үүдэн эмнэлгүүд	434	-	-	841856
Бусад эмнэлгүүд	45	1494	45490	535708
Нийт	1256	18371	558221	13874497

4.1 Эмнэлгийн анхдагч шатлалын тусlamж үйлчилгээ

Сумын болон сум дундын эмнэлгийн тусlamж үйлчилгээ

1 сая 55 мянга гаруй хөдөөгийн хүн амд сумын болон сум дундын эмнэлгийн их эмч - 569, бага эмч -470, багийн бага эмч - 901, нийт 7018 ажиллагсад эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна. Сумын эмнэлгийн амбулаторын үзлэгийн 43.4 хувийг урьдчилан сэргийлэх эзэлж нэг хүн жилд дунджаар 2.4 удаа сумын эмнэлгээр үйлчүүлсэн байна. Эмнэлгийн нийт орны дөрөвний нэг буюу 4579 ор сумын болон сум дундын эмнэлэгт ашиглагдаж, 152022 хүн хэвтэн эмчлүүлж, нэг өвчтөн дунджаар 8.3 хоног эмчлүүлсэн байна.

Өрхийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ. 2004 оны байдлаар 230 өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 915.5 мянган хүн амд 116 өрхийн эмнэлэг, 21 аймгийн аймгийн төвүүдийн 550.9 мянган хүн амд 114 өрхийн эмнэлэг эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна. Өрхийн эмнэлэгт их эмч - 796, сувилагч, бага эмч -794 болон бусад эмнэлгийн ажилчид-435, нийт 2025 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

Хүснэгт 4.3 Ахдагч шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Өрхийн эмнэлэг
Нөөцийн болон хүртээмжийн үзүүлэлтүүд			
Нэг эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн ам	3100	4300	*
Эмчийн дундаж тоо	1.5	3.4	*
Нэг их эмчид ногдох хүн амын тоо	1997	1242	*
Эмнэлгийн орны тоо дундажаар	13	23	*
Нэг оронд ногдох хүн амын тоо	238	188	*
Үйл ажиллагааны үзүүлэлтүүд			
Жилд нэг эмчид ногдох үзлэгийн тоо	4830	3287	*
Дундаж ор хоног	8.3	8.4	*
Үр дүнгийн үзүүлэлтүүд			
Эмнэлэгт хэвтэлт (тоо)	29126	22896	*
Эмнэлэгт хэвтэлт (10000 хүн амд)			
Амбулаторын үзлэгийн тоо	7523.8	11453.9	
Амбулаторийн үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	43.4	39.5	22308
Жилд нэг иргэний үзүүлсэн удаа	2.4	2.6	34.2

4.2 Хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ

2004 оны байдлаар хөдөө орон нутагт хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-4, аймгийн нэгдсэн эмнэлэг -18, УБ хотод 12 дүүргийн эмнэлгийн их эмч - 799, сувилагч - 2661, бусад эмнэлгийн дунд мэргэжилтэн -1274, нийт 8217 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хөдөөгийн хүн амд, УБ хотын хүн амд хоёрдогч шатлалын буюу үндсэн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Нийт эмнэлгийн орны гуравны нэг буюу 6279 ор, нийт хэвтэн эмчлүүлэгдийн 35 хувь буюу мөн гуравны нэг нь хоёрдогч шатлалын буюу аймаг, дүүргийн эмнэлэгт ногдож байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 34 хувийг сумын болон сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна.

/БОЭТөв үзүүлэлтүүд нэмэгдэж орсон /

Хүснэгт 4.4 Хоёрдогч шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эмнэлэг
Нөөцийн болон хүртээмжийн үзүүлэлтүүд			
Эмчийн дундаж тоо	51.4	13.7	52.7
Нэг их эмчид ногдох хүн амын тоо	-	-	-
Эмнэлгийн орны тоо дундажаар	224	70.5	106
Үйл ажиллагааны үзүүлэлтүүд			
Жилд нэг эмчид ногдох үзлэгийн тоо			
Дундаж ор хоног	9.7	9.0	9.6
Үр дүнгийн үзүүлэлтүүд			
Эмнэлэгт хэвтэлт (тоо)	6564	2147	3821
Эмнэлэгт хэвтэлт (10000 хүн амд)			
Хоног болоогүй нас баралт	92743	30890	137576
Амбулаторын үзлэгийн тоо	44.8	36.3	48.2
Амбулаторийн үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
Жилд нэг иргэний үзүүлсэн удаа			

4.3 Гуравдагч шатлалын тусlamж үйлчилгээ

Гуравдагч шатлалын 17 клиникийн эмнэлэг болон төрөлжсөн төвүүдэд их эмч -1133, сувилагч - 1666 , бусад эмнэлгийн дунд мэргэжилтэн – 560 нийт 5295 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. 2004 онд гуравдагч шатлалын эмнэлгүүдэд 110.4 хүн хэвтэн эмчлүүлснээс 36.2 мянган хүн буюу 15 хувь нь хөдөө орон нутгаас илгээсэн өвчтөн эзэлж байна.

Хүснэгт 4.4 Гуравдагч шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Эмнэлгүүдийн нэр	Амбулаторын үзлэгийн тоо	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
Клиникийн I нэгдсэн эмнэлэг	156934	10.1	18
Клиникийн II нэгдсэн эмнэлэг	100892	10.9	21
Клиникийн III нэгдсэн эмнэлэг	147470	9.7	12
Эх нялхсын эрдэм шинжилгээний	130736	7.6	12.1
Гэмтэл согог сэргээн засах	54091	14.3	40
Арьсны өвчин судлалын төв	61711	11.9	-
Халдварт өвчин судлалын төв	120135	17.7	3.8
Хавдар судлалын төв	51451	12.8	5.2

Эмийн улсын бүртгэлийн тухай


Эмийн зах зээлд төрийн бодлогыг хэрэгжүүлэх гол үндэс нь эмийн улсын бүртгэл болохыг дэлхийн улс орнууд нэгэнтэй хүлээн зөвшөөрсөн бөгөөд манай улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогод “Эмийн улсын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох замаар эмийн эмчилгээний идэвхи, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтад тавих шаардлагыг өндөржүүлнэ” гэж заасан билээ.

Мөн “Эмийн тухай” Монгол улсын хуулийн 15.1-д “Эм үйлдвэрлэх, импортлох зөвшөөрөл бүхий байгууллагын үйлдвэрлэх, импортлох эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна” гэжээ.

Манай улс 1992 онд хуралдсан “Эмийн үндэсний бодлого” анхдугаар бага хурлаас иргэдийг аюулгүй, чанарын баталгаатай эмээр үйлчлэх бодлогыг дэвшигүүлэн түүнийг хэрэгжүүлэх зорилгоор 1994 оноос эмийг улсын бүртгэлд бүртгэж эхэлсэн билээ.


Эмийг улсын бүртгэлд бүртгэснээр аюулгүй, чанарын баталгаатай эм хэрэглэх орчин бүрдэх, дотоодын зах зээлд хуурамч, дуураймал эм нэвтрэх үүд хаалгыг хаах, тэдгээрийг илрүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ач холбогдолтой.

Эмийн улсын бүртгэлд 2004 оны байдлаар 1234 нэрийн эм, 28 нэрийн эмийн түүхий эд бүртгэсний 2.6% нь эх орны үйлдвэрийн эм, 97.4% нь импортын эм байна.



Зураг 1. Улсын бүртгэлд хамрагдсан эм (1994-2004)


Эмийн улсын бүртгэлд 33 улсын 1234 эм бүртгэснээс ОХУ-ын эм 372 (30%), Герман улсын эм 185 (15%), Унгар улсын эм 95 (7.7%) байна /Зураг 2/.



Зураг 2. Улсын бүртгэлд хамрагдсан эм (улсаар)

Фармакологийн ангиллаар ангилахад микроб, вирус, паразитын эсрэг нөлөөлөх бэлдмэлүүд 197 (16%), төв мэдрэлийн системд нөлөөлөх эм 114 (9.2%), зүрх судасны системд нөлөөлөх эм 108 (8.8%), хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх эм 61 (5%) амьсгалын эрхтнүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх эм бэлдмэл 32 (2.6%), байна /Зураг 3/.

Зураг 3. Улсын бүртгэлд хамрагдсан эм (фармакологийн ангиллаар)



Цаашид зайлшгүй шаардлагатай эмийн үзэл баримтлалтай уялдуулан эмийн сонголтыг зөв хийх, зайлшгүй шаардлагатай болон улсын бүртгэлтэй эмийн талаархи эрүүл мэндийн байгууллага, ард иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, эм бүртгэхэд улсын бүртгэлтэй болон бүртгэлгүй эмийн талаархи бодит судалгааг үндэслэх, эмийн бодит хэрэгцээ, зохистой хэрэглээний судалгааг тогтмол явуулж байх, эмийн бүртгэлийн дүрмээс гадна бүртгэлд баримтлах өрөнхий бодлоготой байх шаардлагатай байна.

Мэдээлэл бэлтгэсэн З. Зузаан

БҮЛЭГ V

ХАЛДВАРТ ӨВЧИН

2004 онд улсын хэмжээнд 25 төрлийн цочмог халдварт өвчний 31324 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 4443 тохиолдол буюу 10000 хүн амд 15.4%-р нэмэгдсэн боловч сүүлийн 5 жилийн дундажаас 5582 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 27%-р буурсан байна.

Улсын хэмжээнд 2004 онд бүртгэгдсэн халдварт өвчний гаралтыг өнгөрсөн онтой харьцуулбал Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Ховд аймагт нэмэгдсэн байна.

Нийт өвчлөлийн 53.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, 10000 хүн амд 191.9 тохиолдол байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 10000 хүн ам тутамд 50.1 %-р өндөр байна. 2004 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдваруудын өвчлөлийн байдлыг сүүлийн 5 жилийн дундаж өвчлөлтэй харьцуулбал нийт аймаг, Улаанбаатар хотод буурсан үзүүлэлттэй байна.

Сүрьеэ, тэмбүү, заг хүйтэн, улаанууд, цусан суулга, хоолны хордлогот халдвэр, балнад, вируст гепатит А, В, улаан эсэргэнэ, хамуу, боом, ёлом, улаанууд, нярайн үжил, мөөгөнцөртөх, халдварын гаралт өнгөрсөн оноос нэмэгдсэн байна.

Сүрьеэ, цусан суулга, балнад, хоолны хордлогот халдвэр, боом, тэмбүү, трихомионаз, заг хүйтэн, салхинцэцэг, хамуу, мөөгөнцөрдөх, хачигт энцефалит өвчний 10000 хүн амд бүртгэгдсэн тохиолдол сүүлийн 5 жилийн дундажаас өндөр байна.

5.1 Гэдэсний халдвэр

Гэдэсний халдварт 6 өвчин буюу вируст гепатит А, балнад, цусан суулга, сальмонеллээз, хоолны хордлогот халдвэр, халдварын гаралтай суулгалт өвчний нийт 7938 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 25.3 хувийг эзэлж, өмнөх оноос 1705 тохиолдлоор буюу 14.1 %-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Вируст гепатит

Нийт халдварт өвчний 19.7 % -ийг эзэлж, 6164 тохиолдол бүртгэгдэн, 10000 хүн амд 24.8 өвчлөл оногдож байгаа нь өмнөх оноос 5%-р нэмэгдсэн байна.

- Вируст гепатит А нь гэдэсний халдварт өвчний (ГХӨ) дотор 65.9 хувийг эзэлж байна. Вируст гепатит А нь өмнөх оноос 1277 тохиолдол буюу 4.7 %-р, вируст гепатит В - 62 тохиолдол, вируст гепатит - С 15 тохиолдолоор тус тус нэмэгдсэн байна.
- Нийт вируст гепатит Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод 4.3-46.5%-р нэмэгдсэн байна.
- Вируст гепатит А Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод,
- Вируст гепатит В Булган, Говьсүмбэр, Дархан Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс, Хэнтий,
- Вируст гепатит С Дархан Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Увс, Улаанбаатар хотод урьд тус тус нэмэгдсэн байна.

Вируст гепатит өвчний тухайн насы 10000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээс харахад: Вируст гепатит В-ээр өвчлөгсөд 10-44 насанд хамгийн өндөр 94,7 байхад вируст гепатит А-аар 1-24 насанд зонхилон өвчилж, 4945 тохиолдол буюу 95,3 хувь байна. Вируст гепатит А-ийн өвчлөлийг тухайн насы 10000 хүн амд авч үзвэл 2 насанд 104,2%, 3 насанд 129,9%, 4 насанд 139,3%, 5-9 насанд 58,6 % байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин вируст гепатит В-ийн өвчлөл 15-19 насанд 8,5%, 20-24 насанд 10% байгаа нь өнгөрсөн оны мөн үеийн өвчлөлөөс 1,1-1,8%-ээр нэмэгдсэн. Вируст гепатит В –ийн вакцинд хамрагдсан байх насы хүүхдийн өвчлөл цөөн байгаа боловч 14 хүртэлх насанд өвчлөл 11,1% байна.

Зураг 5.1



Цусан суулга

Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 7.1 хувь, гэдэсний халдварт өвчний 27.9 хувийг тус тус эзэлж, өвчлөл өнгөрсөн оноос 206 тохиолдоор буюу 0.9 %-р нэмэгдсэн байна. Бүртгэгдсэн нийт халдварын 71,2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба Дорнговь (12,3), Өмнөговь (35,8) аймгууд, Улаанбаатар хотод (18,1) өвчлөл улсын дундаж (8.9)-аас өндөр, Говьсүмбэр, Дархан-Уул, Завхан, Өмнөговь, Төв аймаг, Улаанбаатар хотод өвчлөл өнгөрсөн оноос 0,3-30,1%-ээр нэмэгдсэн байна.

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын мэргэжлийн сургалттай дунд сургуулийн дотуур байрны сурагчдын дунд 2004 оны 3 дугаар сард Sh. Flexneri 4a-р үүсгэгдэж усаар дамжсан цусан суулгын тахал дэгдэлт гарч 113 сурагч, гэрийн голомтын 7 хүн, сургуулийн гал тогооны 3 ажилчин өвчилсөн.

Өвчлөгсөдийн насын байдлыг авч үзэхэд өвчлөл бүх насанд бүртгэгдсэн бөгөөд 0-9 насанд зонхилон өвчилж, 1302 тохиолдол бүртгэгдсэн нь цусан суулгын нийт өвчлөлийн 58,8% эзэлж байна.

10000 хүн ам тутамд өвчлөл 1 насанд 82.3%, 2 насанд 73.9% байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Балнад

Улсын хэмжээнд Дорноговь (1), Өвөрхангай (9), Сүхбаатар (2) аймгууд, Улаанбаатар хот (2)-д нийт 14 тохиолдол бүртгэгдсэн. Балнадын өвчлөл өмнөх оноос 6 тохиолдоор нэмэгдсэн.

2004 оны 8 дугаар сард Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 2 дугаар багт гэдэсний балнад өвчний тахалт тархалт гарч 9 хүн өвчилсөн. Уг халдвартын голомтонд хийсэн судалгаа, дүгнэлтээс үзэхэд нян тээгчээс халдварт ахуйн замаар дамжсан бөгөөд халдвартын анхны тохиолдлыг эрт илрүүлээгүйгээс халдварт тархан олон хүнийг өвчлүүлсэн байна.

Хүнсний гаралтай бактерит хордлого

Нийт халдварт өвчний 1.0 хувь, гэдэсний халдварт өвчний 4.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт 241 тохиолдол Дундговь (1), Орхон (3), Төв (5), Хөвсгөл (1) аймгууд болон Улаанбаатар хот (231)-д бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 1,0 өвчлөл ноогдож байна.

Улаанбаатар хотод хүнсний гаралтай бактерит халдвартын 231 тохиолдол буюу 10 000 хүн амд 2.7 %-р нэмэгдэж улсын хэмжээний өвчлөлийн 95. 8 хувийг эзэлж байна. 2004 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж байсан “Амтлаг” нарийн боовны цехэд үйлдвэрлэсэн бялуунаас үүдэлтэй *Salmonella enteritidis*-ээр үүсгэгдсэн хоолны хордлогот халдвартын тахал тархалт гарч 197 хүн өвчилсөн.

5.2 Амьсгалын замын халдварт

Сүрьеэз

Сүүлийн жилүүдэд сүрьеэгийн өвчлөл тогтвортой өндөр байгаа бөгөөд 2004 оны байдлаар бүртгэгдсэн нийт халдварт өвчний 14 хувь, амьсгалын замын халдвартын 70.3 хувийг тус тус эзэлж байна. 2004 оны байдлаар сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 17.6 % байгаа нь урьд оныхоос 2.4 %-р нэмэгджээ. Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдолын тоо 4392, уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тохиолдол 1808 байгаа нь урьд оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт шинэ тохиолдол 620 буюу 16.0%-иар, уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тохиолдол 267 буюу 16.8%-иар тус тус нэмэгдсэн байна. Нийслэл хотод шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн 2300 тохиолдолын 3.8%-ийг хөдөө орон нутгийн түр оршин суугчид, 3.4%-ийг орон гэргүй, хаяггүй хүмүүс эзлэж байна.

